



**Харилцаа холбооны зохицуулах хорооны
2025 оны ээлжит 08 дугаар хуралдааны
мэдээлэл**

Монгол Улсын Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 08 дугаар хуралдааныг 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан.

Харилцаа холбооны зохицуулах хорооны 2025 оны ээлжит 08 дугаар хуралдаанаар /2025-05-05/ Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт болон ОранжКом ХХК-ийн гомдолтой холбогдуулан боловсруулсан танилцуулга, холбогдох эрхзүйн дүгнэлтийн тухай (Хорооны 2025 оны 75 тоот тогтоол) асуудлыг хэлэлцэн зохицуулах хорооны 16 (Тогтоол №86-97, 2025-05-05) тогтоолыг батлан шийдвэрлэсэн болно.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 08 дугаар хуралдаанаар Тусгай зөвшөөрөл олгох, зөвшөөрлийн хугацаа сунгах, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох тухай үнэлгээ, дүгнэлт; Харилцаа холбооны сүлжээний дугаарын хугацаа сунгах тухай үнэлгээ, дүгнэлт болон ОранжКом ХХК-ийн гомдолтой (2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр, Оранжком ХХК-иас Харилцаа холбооны зохицуулах хороонд 25/061 тоот албан бичгээр гаргасан гомдлын тухай) холбогдуулан гаргасан эрхзүйн дүгнэлтийн тухай (Хорооны 2025 оны 75 тоот тогтоол) болон холбогдох газар, хэлтсийн боловсруулсан танилцуулга, үнэлгээний дүгнэлт бүхий 16 тогтоолын төслийг хавсралтын хамт тус тус хэлэлцээд, тус хуралдаанаас 16 тогтоолыг хавсралтын хамт батлан шийдвэрлэсэн. Үүнд:

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Радио долгионы тухай хуулийн 5¹ дүгээр зүйлийн 5¹.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 86 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 1 хуулийн этгээдэд 1 тусгай зөвшөөрлийг (Юнивишн ХХК: Утасгүй интернэтийн үйлчилгээнд “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах”) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 87 тоот тогтоолыг баталж, тогтоолын хавсралтаар 2 хуулийн этгээдэд 2 тусгай зөвшөөрлийг (Си Эйч Би ави номад экспресс карго ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс – Канад Улс/; Альфа карго ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс – БНХАУ/) шинээр олгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 88 тоот тогтоолыг баталж, тогтоолын

хавсралтаар 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Эйр пасифик ХХК: Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх /Чиглэл: Монгол Улс–ХБНГУ/, 43200125 тоот) сунгасан;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 89 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Скайнэтворкс ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ байгуулах, түүний ашиглалт үйлчилгээ эрхлэх”, 17000001 тоот) сунгасан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.10 дахь заалтыг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 90 тоот тогтоолыг баталж, тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрөлд (Оримедиа ХХК: 13400120 тоот Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт “Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх” тусгай зөвшөөрлийн хамрах хүрээг Монгол Улсын нутаг дэвсгэрт болгон өөрчлөх) нэмэлт оруулсан;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Баянтүмбэ трейд ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 91 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Баянтүмбэ трейд ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43200090 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Шуудангийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4 дэх заалт, Карголинк ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 92 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Карголинк ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Улс хоорондын шуудангийн үйлчилгээ эрхлэх” 43100008 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Мобиком нэтворкс ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 93 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Мобиком нэтворкс ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” 26700002 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсэг, Радио долгионы тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалт, Хасүби медиа ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 94 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 2 тусгай зөвшөөрлийг (Хасүби медиа ХХК: Хөвсгөл аймгийн нутаг дэвсгэрт “Арилжааны радиогийн үйлчилгээ эрхлэх” 12800209 тоот болон Хөвсгөл аймгийн Тариалан сумын нутаг дэвсгэрт “Радио давтамж, радио давтамжийн зурвас ашиглах” 22800216 тоот тусгай зөвшөөрлүүдийг) хүчингүй болгосон;

- Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, 6.2 дугаар зүйлийн 1.1 дэх хэсэг, Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.2 дахь заалт, Скайнэтворкс ХХК-ийн хүсэлтийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 95 тоот тогтоолыг баталж, уг тогтоолоор 1 хуулийн этгээдийн 1 тусгай зөвшөөрлийг (Скайнэтворкс ХХК: Монгол Улсын нутаг дэвсгэрт “Харилцаа холбооны сүлжээ, дэд бүтцийн суурилуулалт, засвар үйлчилгээ эрхлэх” 12100743 тоот тусгай зөвшөөрлийг) хүчингүй болгосон;
- Харилцаа холбооны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн 96 тоот тогтоолыг баталж, уг тогтоолын хавсралтаар 3 иргэн, хуулийн этгээдийн (Номин холдинг ХХК; Мэдээллийн аюулгүй байдлын газар; Иргэн А.Орхонцэцэг) 3 харилцаа холбооны сүлжээний дугаарын ашиглалтыг 2 жилийн хугацаатай сунган тус тус шийдвэрлэв.

ХХЗХ-ны 2025 оны ээлжит 08 дугаар хуралдаанаар Ажлын албанаас Оранжком ХХК-ийн гомдолтой (2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр, Оранжком ХХК-иас Харилцаа холбооны зохицуулах хороонд 25/061 тоот албан бичгээр гаргасан гомдлын тухай) холбогдуулан боловсруулсан танилцуулга, Хорооны Даргын зөвлөлийн 2025 оны 11 дүгээр хурлын тэмдэглэл, Хуулийн хэлтсээс гаргасан эрхзүйн дүгнэлт, Хорооны “Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхээс татгалзаж, захиргааны актыг хэвээр үлдээх тухай” тогтоолын төслийг тус тус хэлэлцээд, Захиргааны ерөнхий хуулийн 95 дугаар зүйлийн 95.8, 98 дугаар зүйлийн 98.1.5, 99 дүгээр зүйлийн 99.1 дэх хэсгийг тус тус үндэслэн 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэхээс татгалзаж, захиргааны актыг хэвээр үлдээх тухай” 97 тоот тогтоолыг батлав. Энэхүү тогтоолд, “Оранжком ХХК-ийн 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 25/061 тоот албан бичгээр ирүүлсэн гомдлыг хянан үзсэн Хорооны Даргын зөвлөлийн 2025 оны 11 дүгээр хурлын тэмдэглэлийг үндэслэн тус хорооны 2025 оны 75 тоот тогтоолын биелэлтийг түдгэлзүүлэхээс татгалзаж, тогтоолыг хэвээр үлдээсүгэй; Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Оранжком ХХК-д ажлын 5 /тав/ өдрийн дотор мэдэгдэхийг тус Хорооны хуралдааны нарийн бичгийн дарга /Т.Наранмандах/-д үүрэг болгосугай; Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.” гэжээ.

(Хуралдааны баталсан тогтоолын жагсаалт, холбогдох хавсралтыг).

Харилцаа холбооны зохицуулах хороо
2025-05-08